

**2019 ОНЫ 2 ДУГААР САРЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮЛЭЭГДЛИЙН МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/427 тушаалын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдэл бүртгэгдсэн 7 байгууллага /УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, СЭМҮТ, НЭМГ/ мэдээ ирүүлсэн.

Нэг. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн амбулаторийн үзлэгийн хүлээгдэл:

2019 оны 2 дүгээр сард хүлээгдлийн мэдээ ирүүлсэн байгууллагуудаас амбулаторийн үзлэг УНТЭ 271, УХТЭ 207, УГТЭ 45 хүлээгдэл бүртгэгдсэн байна. Өмнөх сарын хүлээгдэлтэй харьцуулахад УНТЭ 252 тохиолдлоор УГТЭ 43 тохиолдлоор буурсан байна.

УНТЭ-ийн амбулаторийн 12 кабинетэд нийт 271 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдэж, өмнөх сарын хүлээгдлээс 246 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. Үүнд:

- Бөөрний кабинет 6 хүлээгдэл
- Зүрх судасны кабинет 28 хүлээгдэл
- Уушигны кабинет 1 хүлээгдэл
- Мэдрэлийн кабинет 48 хүлээгдэл
- Нүдний кабинет 25 хүлээгдэл
- Нүдний даралтын кабинет 32 хүлээгдэл
- Чих хамар хоолойн кабинет 14 хүлээгдэл
- Дотоод шүүрлийн кабинет 1 хүлээгдэл
- Урологийн кабинет 5 хүлээгдэл
- Хэрх үений кабинет 12 хүлээгдэл
- Шүдний кабинет 12 хүлээгдэл
- Хоол боловсруулах эрхтэн судлалын кабинет 87 бүртгэгдэж тус бүр 1-7 хоногийн хугацаатай хүлээсэн байна.

УХТЭ-т нийт 7 кабинетэд 294 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Үүнд:

- Бөөр судлалын кабинет 24
- Зүрх судасны кабинет 16
- Уушигны кабинет 26
- Мэс заслын кабинет 116
- Мэдрэл судлалын кабинет 45
- Уламжлалтын кабинет 45
- Хоол боловсруулах эрхтэн судлалын кабинет 22 үйлчлүүлэгч тус тус 1-3 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

УГТЭ-ийн зүрх судасны кабинетэд 60, мэдрэлийн кабинетэд 49, хоол боловсруулах эрхтэн системийн кабинетэд 60 хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 14 кабинетэд 423 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.


ХСҮТ-ийн амбулаторийн 14 кабинетэд нийт 526 үйлчлүүлэгч үйлчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнд:

- Зүрх судасны кабинет 32

- Мэс засал 38
- Сэргээн засах 1
- Элэг цэс нойр булчирхайн кабинет 51
- Толгой хүзүүний мэс заслын кабинет 33
- Эмэгтэйчүүдийн мэс заслын кабинет 90
- Цээжний хөндийн мэс заслын кабинет 48
- Гепатологийн кабинет 28
- Хөнгөвчлөх 17
- Туяа эмчилгээний кабинет 25
- Хими эмчилгээний кабинет 56
- Ангиографийн кабинет 32 үйлчлүүлэгч тус бүр 1-7 ба түүнээс дээш хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ. Өдөртөө үйлчлүүлсэн 75 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

ЭХЭМҮТ, СЭМҮТ амбулаторийн хүлээгдэлгүй байна.

УНТЭ, УХТЭ, УГТЭ-ийн 2019 оны 2-р сарын амбулаторийн хүлээгдлийг үйлчлүүлэгчдийн тоогоор харьцуулсан нь:



ХСҮТ-ийн 2-р сарын амбулаторийн хүлээгдлийг үйлчлүүлэгчдийн тоогоор харьцуулсан нь:



Хоёр. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн оношлогооны кабинетийн хүлээгдэл:

2019 оны 2 дугаар сард УНТЭ, УГТЭ, ХСҮТ, СЭМҮТ-ийн оношлогооны тасгуудад хүлээгдэл бүртгэгдсэн байна.

УНТЭ-т оношлуулахаар 174 үйлчлүүлэгч 2-15 түүнээс дээш хоног хүлээгдэж байгаа нь өмнөх сарын хүлээгдлээс 19 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна.

Үүнд:

- Рентген зураг 40
- Хэвлийн эхо 33
- Тархины цахилгаан бичлэг 3
- Бүдүүн гэдэсний дуран 60
- Урологийн оношилгооны дуран 38 үйлчлүүлэгч оношлуулахаар 2-14 түүнээс дээш хоног тус тус хүлээж үйлчлүүлсэн байна.

УХТЭ-т оношлуулахаар 263 үйлчлүүлэгч 2-15 түүнээс дээш хоног хүлээгдэлтэй байна. Үүнд:

- Рентген зураг 66
- Зүрхний цахилгаан бичлэг 70
- Хэвлийн эхо 86
- Ходоодны дуран 19
- Тархины цахилгаан бичлэг 1
- Допплер 17
- Нүдний уг 3
- MRI 1 үйлчлүүлэгч оношлуулахаар 2-14 түүнээс дээш хоног тус тус хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 156 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-т оношлуулахаар 172 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

Үүнд:

- Рентген зураг 27
- Зүрхний цахилгаан бичлэг 59
- Хэвлийн эхо 62
- Тархины цахилгаан бичлэг 9
- Зүрхний ЭХО 4
- Допплерографи 11 үйлчлүүлэгч тус бүр 1-2 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 134 үйлчлүүлэгч байна.


ХСҮТ-д анх удаа оношлуулахаар дугаар авсан 180 үйлчлүүлэгчээс өдөртөө үйлчлүүлсэн 18 үйлчлүүлэгч, 7 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй 46, 1-6 хоногийн хүлээгдэлтэй 116 үйлчлүүлэгч байна.

Үүнд: Бүдүүн шулуун гэдэсний дуран 1 үйлчлүүлэгч, уушигны дуран 4, ходоодны дуран 30, хэвлийн ЭХО 92, зүрхний цахилгаан бичлэг 32, КТГ 3 үйлчлүүлэгч тус бүр 1-14 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ.


Өдөртөө үйлчлүүлсэн 18 үйлчлүүлэгч байна.

СЭМҮТ-ийн эмгэг сэтгэл судлалын шинжилгээ хийлгэхээр 187 үйлчлүүлэгч бүртгэгдсэний 69 өдөртөө, 31 үйлчлүүлэгч 1 хоног, 37 үйлчлүүлэгч 2 хоног, 40 үйлчлүүлэгч 3-6 хоног 10 үйлчлүүлэгч 7-14 хоног хүлээж үйлчлүүлсэн байна

УНТЭ,УХТЭ, УГТЭ, ХСҮТ-ийн оношлогооны кабинетийн 2-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



СЭМҮТ-ийн эмгэг сэтгэл судлалын оношилгооны кабинетын 2018 оны 12 сар 2019 оны 1, 2 сарын хүлээгдэл /үйлчлүүлэгчийн тоогоор/



Гурав. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн лабораторийн шинжилгээний хүлээгдэл:

2019 оны 2 дугаар сард УНТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, СЭМҮТ эмнэлгүүд лабораторийн шинжилгээний хүлээгдэлгүй.

УХТЭ, УГТЭ-т лабораторийн шинжилгээний хүлээгдлийг бүртгэн мэдээлсэн.

УХТЭ-т лабораторийн нийт хүлээгдэл 862 үйлчлүүлэгч 1-6 хоногийн хүлээгдэлтэй байна. Үүнд: Цусны ерөнхий шинжилгээ 109, шээсний ерөнхий шинжилгээ 77, биохими

599, бактериологийн шинжилгээ 32, иммунологийн шинжилгээ 13, сериологийн шинжилгээ 2, коагулограммын шинжилгээ 22 үйлчлүүлэгч 1-6 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.


Өдөртөө үйлчлүүлсэн 505 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-т лабораторийн нийт хүлээгдэл 252 үйлчлүүлэгч 1-2 хоногийн хүлээгдэлтэй байна. Үүнд: Цусны ерөнхий шинжилгээ 89, шээсний шинжилгээ 39, биохимийн шинжилгээ 101, бактериологийн шинжилгээ 23 үйлчлүүлэгч 1-2 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

Серологи, цитологи, иммунологи коагулограммын шинжилгээнүүд хүлээгдэлгүй.

Өдөртөө үйлчлүүлсэн 271 үйлчлүүлэгч байна.

УХТЭ, УГТЭ-ийн лабораторийн кабинетийн 2019 оны 2-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



Дөрөв. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

2019 оны 2 дугаар сард хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг УХТЭ, УГТЭ, ХСҮТ, СЭМҮТ бүртгэн мэдээлсэн. УНТЭ-ийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэлгүй байна.

УХТЭ-т 2-р сард нийт 294 үйлчлүүлэгч 1 хоногоос 30 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна. Үүнд: Бөөрний тасагт 24, зүрх судасны системийн тасаг 16, уушигны тасагт 26, мэс заслын тасагт 116, мэдрэлийн тасагт 45, уламжлалт эмчилгээний тасагт 45, хоол боловсруулах эрхтэн системийн тасагт 22 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-т 2-р сард нийт 83 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнээс: Бөөрний тасагт 6, зүрх судасны системийн тасагт 10, уушигны тасагт 5, мэс заслын тасагт 6, мэдрэлийн тасагт 12, нүдний тасагт 9, хоол боловсруулах эрхтэн системийн тасагт 6, чих хамар хоолойн тасагт 12, мэдрэлийн мэс засалд 17 үйлчлүүлэгч тус тус 1-30 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна.

ХСҮТ-д 2-р сард нийт 416 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнд: 1-3 хоногийн хугацаанд 80 үйлчлүүлэгч, 3-6 хоногийн хүлээгдэлтэй 72

үйлчлүүлэгч, 7-14 хоногийн хүлээгдэлтэй 153 үйлчлүүлэгч, 15-30 хоногийн хүлээгдэлтэй 96 үйлчлүүлэгч, 1 сараас дээш хүлээгдэлтэй 15 үйлчлүүлэгч байна.

ХСҮТ нь яаралтай тусламжаар өдөрт дунджаар 10 өвчтөн ирдэг, нийт ирж буй үйлчлүүлэгчдийн 98% нь хорт хавдрын хожуу шатандаа орсон өвчтөнүүд байдаг ба үүнээс хэвтэх шаардлагатай өвчтөнүүдийг хөнгөвчлөх болон бусад мэс заслын тасгуудад хэвтүүлдэг учир орны зөрүүтэй байдал үүсдэг.

Химийн тасгаар өвчтөн 14-21 хоногийн давтамжтай “товлолт” эмчилгээнд хамрагддаг тул хүлээгдэлтэй харагдаж байна .

Ангиографийн тасаг нь өдөрт дунджаар 10 өвчтөнд ажилбар хийдэг ба тус тасгийн дундаж ор хоног 1.6 тул ажилбар хийлгэхээр хүлээж буй өвчтөний тоо их байна.

СЭМҮТ-ийн стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 1-3 хоногийн хугацаанд хүлээж байгаа 3 үйлчлүүлэгч, 42 үйлчлүүлэгч 3-6 хоног, 96 үйлчлүүлэгч 7-14 хоног, 36 үйлчлүүлэгч 15-30 хоногийн хугацаанд нийт 173 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна.

ЭХЭМҮТ-ийн эмэгтэйчүүдийн эмгэг судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 1-3 хоногийн хугацаанд 2 үйлчлүүлэгч хүлээж үйлчлүүлсэн.

СЭМҮТ-ийн стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт 124 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байгаа нь өмнөх сартай /88/ харьцуулахад 36 тохиолдлоор нэмэгдсэн байна. Тус тасагт хэвтэн эмчлүүлэхээр 1-3 хоногийн хугацаанд хүлээж байгаа 17, 3-6 хоног 31, 7-14 хоног 76 үйлчлүүлэгч байна.

СЭМҮТ-ийн неврозын тасгийн хүлээгдэл



Тав. НЭМГ-ын харъяа эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

НЭМГ-ын харъяа 8 эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэл бүртгэгдсэн байна. Эдгээрээс хамгийн олон хоногийн хүлээгдэл Сонгинохайрхан дүүргийн дотор 64, мэдрэл 41, БГДЭМТ-ийн дотор 47, мэдрэл 64, Хан уул дүүргийн эрүүл мэндийн төвийн дотор 65, мэдрэл 40, Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвийн дотор 68, налайх дүүргийн эрүүл мэндийн төвийн дотор 70, ахмадын эмнэлэг 54 үйлчлүүлэгч тус бүр 1-30 хоногийн хүлээгдэлтэй үйлчилсэн байна.


Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2019 оны 2-р сарын хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг хүснэгтээр харуулав.

Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2019 оны 2 сарын хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдлийн мэдээ										
№	Үзлэгийн кабинетын нэр	Үзүүлэлт	2 сарын хүлээгдэл							
			СХД ЭМТ	ХУД ЭМТ	ЧД ЭМТ	НД ЭМТ	БН ЭМТ	БГД ЭМТ	БЗД НЭ	СБД НЭ
1	Мэдрэл	Ор хүлээж байгаа өвчтний тоо	41	40	0	15	22	47	0	0
		1-3 хоног		16		5		2		
		3-6 хоног		13		7	2	6		
		7-14хоног	11	11		2	10	32		
		15-30 хоног	30			1	10	7		
		1 сараас дээш								
2	Дотор	Ор хүлээж байгаа өвчтний тоо	64	65	68	70	14	64	63	0
		1-3 хоног		14	36	28		3	10	
		3-6 хоног		22	23	23	10	6	9	
		7-14хоног	38	17	9	14	4	16	19	
		15-30 хоног	26	12		5		39	25	
		1 сараас дээш								
4	Ахмадын эмнэлэг	Ор хүлээж байгаа өвчтний тоо	54	0	0	0	0	14	0	0
		1-3 хоног						7		
		3-6 хоног						7		
		7-14хоног	50							
		15-30 хоног	4							
		1 сараас дээш								
5	Уламжлалт	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0
		1-3 хоног								
		3-6 хоног								
		7-14хоног								
		15-30 хоног								
		1 сараас дээш								

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 2 дугаар сард 27032 дуудлага бүртгэгдсэний 32.3%-ийг 0-20 минутад, 33%-ийг 21-40 минутад, 17.5%-ийг 41-60 минутад, 17.2 %-ийг 1 цагаас дээш хугацаанд хүрч үйлчилсэн байна.

Түргэн тусламжийн төвийн 2 дугаар сарын тусламж үйлчилгээний хүлээгдлийг өмнөх сартай харьцуулахад 1 цагаас дээш хугацаанд очсон дуудлага 4.4%-иар буурсан, хамгийн бага хугацаанд \0-20 минут\ хүрч үйлчилсэн тохиолдол 3,2%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 2019 оны 1-2 саруудад ирсэн дуудлагын тоо /хүрч үйлчилсэн хугацаагаар/



Нийслэлийн түргэн тусламжийн төвд сүүлийн 6 сарын хугацаанд ирсэн нийт дуудлагын тоо:



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ, ЛИЦЕНЗИЙН АЛБА